

**ДЦУБ болон БНЭУ-ын Пүне хотын цаг уурын бүсийн сургалтын төвөөс хамтран зохион байгуулсан “Цаг агаарыг урьдчилан мэдээлэх чадварыг хөгжүүлэх” сэдэвт богино хугацааны сургалтанд хамрагдсан товч тайлан**

Улаанбаатар

2024.10.02

Нислэгийн Цаг Уурын төвийн урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер Б.Тэмүлүн нь 2024 оны 08-р сарын 26-наас 09-р сарын 27-ны өдрүүдэд зохион байгуулсан ДЦУБ болон БНЭУ-ын Пүне хотын цаг уурын бүсийн сургалтын төвөөс хамтран зохион байгуулсан **“Цаг агаарыг урьдчилан мэдээлэх чадварыг хөгжүүлэх”** сэдэвт богино хугацааны сургалтанд хамрагдсан.

Энэхүү олон улсын сургалтын зорилго нь цаг агаарын зураг мэдээллүүд, ажиглалтын мэдээ, хиймэл дагуул, радарын дата болон тоон загварын үр дүнгүүд дээр суурилсан анализ хийж, цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэх чадвараа нэмэгдүүлж, цаг агаарын аюулт үзэгдлээс ард иргэдийг сэрэмжлүүлж, нөлөөлд суурилсан цаг агаарын урьдчилсан мэдээний ур чадварыг хөгжүүлэх явдал юм.

Сургалтад Балба, Бахрейн, Бутан, Йемен, Казахстан, Лаос, Мальдив, Мьянмар, Монгол, Оман, Саудын Араб, Туркменистан, Энэтхэг зэрэг нийт 13 орны 25 хүн оролцсон. БНЭУ-ын цаг уурын бүсийн төвүүдийн эрдэмтэд болон цаг уурын байгууллагуудын урьдчилан мэдээлэхийн ахлах мэргэжилтнүүд хичээл заасан.

Нийт 5-н 7 хоног буюу 25 өдрийн турш онол, семинар дадлага бүхий дараах агуулга сэдвүүдийн хүрээнд явагдсан. Үүнд:

- Цаг агаарыг урьдчилан мэдээлэх хяналт, шинжилгээ
- Цаг агаарыг урьдчилан мэдээлэх арга зүй
- Хэт халуун болон хүйтэн температурыг үүсгэх цаг агаарын нөхцөл
- Орон нутгийн шинж чанартай хүчтэй салхи, аянга цахилгаан, нөөлөг салхины цаг агаарын нөлөөлөл
- Азийн зуны улирлын монсуны хур тунадас
- Тропикийн циклон/Догшин хуй/, түүнийг урьдчилан мэдээлэх арга зүй
- Манан, түүнийг урьдчилан мэдээлэх арга зүй
- Ус, цаг уурын мэдээллийг хэрэглэгчдэд түгээх
- Ус, цаг уурын мэдээлэл үйлчилгээний чанарын менежмент

Дээрх сэдвүүдийн хүрээнд онол болон дадлагын хичээлүүдийг тухай бүрт нь хослуулан явуулсан бөгөөд БНЭУ-ын цаг агаарын тоон загварчлалын төвийн датан дээр тулгуурлан зураг мэдээнд анализ хийж, олон загварын үр дүнгүүд дээр зэрэг ажиллан дүн шинжилгээ хийж, тропикийн циклоны шилжилт хөдөлгөөнийг урьдчилан мэдээлж, түүнтэй холбоотой цаг агаарын аюулт үзэгдлүүдийг ард иргэдэд товч оновчтой, ойлгомжтой байдлаар цаг алдалгүй түргэн шуурхай мэдээлж, УСМ, СМ, харанга, аюулт үзэгдлийн нөлөөллийг ард иргэдэд ойлгуулах, улмаар нөлөөлөлд суурилсан цаг агаарын мэдээг урьдчилан мэдээлэх чадвартай болох нь уг сургалтын онцлог байсан.

## **Дүгнэлт:**

Энэхүү олон улсын сургалтанд сууснаар БНЭУ-ын цаг агаарын урьдчилсан мэдээндээ ашиглаж буй дэвшилтэт технологи болон бусад хөгжиж буй улс орнуудын цаг агаарын урьдчилсан мэдээний холбогдох талбарт ажиллаж буй цаг уурчидтай туршлага солилцож, мэдээлэл хуваалцсан. Цаашид дэлхий дахинд нөлөөлөлд суурилсан цаг агаарын урьдчилсан мэдээний хангалт хэр чухал болохыг анхаарч, өөрсдийн салбарын хэрэглэгчид болох нисгэгчид, нислэгийн удирдагчид, авиа компаниудын операторууд, аэродромын инженер, техникийн ажилчид, аэродромын галын албаны ажилчид зэрэгт цаг агаарын урьдчилсан мэдээний хангалтыг илүү оновчтой, ойлгомжтой байдлаар чанартай, өндөр таарцтай мэдээлэхэд дэм болохуйц сургалт болсон.

Цаашид хийх ажил:

Хичээлийн хөтөлбөрийн хүрээнд МҮХ-ийн ерөнхий технологич инженерүүдэд сургалт зохион байгуулах

Тайлан бичсэн:

Урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер:

Б.Тэмүлүн